



МОНГОЛЫН
ҮНЭТ ЦААСНЫ БИРЖ
Mongol Securities Exchange

2020 ОНЫ ЖИЛИЙН ТАЙЛАН

МОНГОЛЫН ҮНЭТ ЦААСНЫ БИРЖ

Бирж 2020 онд ...

“Монголын Үнэт Цаасны Бирж” ХК нь өөрийн эрхэм зорилгын хүрээнд, хуулиар хүлээсэн үндсэн үүрэгт ажил болох үнэт цаасны арилжааг болон арилжаанд оролцогчдыг зохион байгуулах, бүртгэх, арилжааны дараах төлбөр тооцоог гүйцэтгэх, эрсдэлийг удирдах, олон нийтийг арилжааны болон бусад шаардлагатай мэдээллээр ил тод, шуурхай хангах үйл ажиллагаагаа тогтмол явуулж байна.

Биржийн болон биржийн бус зах зээлд үнэт цаас гаргахаар төлөвлөж байгаа компаниудын ирүүлсэн өргөдөл, бичиг баримтыг шалгаж, шаардлагатай зөвлөгөөг өгөхийн зэрэгцээ одоо Биржид арилжаалагдаж байгаа болон төлбөр тооцоо гүйцэтгүүлж байгаа үнэт цаас, түүнийг гаргагч компаниудад хууль, тогтоомжийн нэмэлт өөрчлөлттэй холбоотой шаардлагатай мэдээллийг хүргүүлсэн. Энэ онд гурван компанийн биржийн бус зах зээлд гаргасан бондын төлбөр тооцоо гүйцэтгэх гэрээг байгуулсан.

Бүртгэл

Энэ онд бид анх удаа нээлттэй хувьцаат компанийн хаалттай хүрээнд санал болгосон бондын төлбөр тооцоог гүйцэтгэхээр ажиллаж байна. “Инвескор” ХК-ийн бичиг баримт, Санхүүгийн Зохицуулах Хорооны зөвшөөрлийг хүлээн авч, тус компанийн өргөдлийг шийдвэрлэн, тухайн компанийн бондын төлбөр тооцоо гүйцэтгэх гэрээг 2020 оны 4 дүгээр сард байгуулсан. Түүнчлэн Бирж дээр бүртгүүлэх хүсэлт гаргасан компаниудтай танилцаж, тэдгээрийн өргөдлийг шийдвэрлэх, бичиг баримтад холбогдох өөрчлөлт оруулах, зөвлөгөө өгөх ажил тогтмол явагдаж байна.

2020 оны эцсийн байдлаар Биржид нэг нээлттэй хувьцаат компани бүртгэгдэж, нэг бүртгэлтэй бондын төлбөр тооцоо, эргэн төлөлт бүрэн хийгдсэн үзүүлэлттэй байгаа бөгөөд биржийн бус зах зээлд нийт таван хаалттай хүрээнд арилжигдах компанийн бонд, нэг хаалттай компанийн хувьцаа бүртгэгдээд байна.

Биржийн бүртгэлийн шаардлагын дагуу бирж дээр бүртгэгдсэн компаниуд нийцүүлэгчээр дамжуулан зах зээлд тогтмол мэдээ гаргадаг нь бидний давуу талын нэг юм. Биржийн болон биржийн бус зах зээлд үнэт цаас гаргагчийн талаарх мэдээллийг www.msx.mn цахим хуудаснаас авах боломжтой. Цахим хуудаст мөн Бирж дээр үнэт цаас гаргах болон арилжаанд оролцох боломж,

давуу тал, төлбөр тооцоо, эрсдэлийн удирдлага, гишүүнчлэлийн мэдээллүүд, үнэт цаасны арилжааны болон ханшийн мэдээ, үнэт цаас гаргагч компаниудын мэдээ, тайлангуудыг зохих хугацаанд нь гаргадаг.

Арилжаа

Тайлант хугацаанд анхдагч зах зээлд хувьцаа болон бондын арилжаа явагдаагүй бөгөөд хоёрдогч зах зээлд 2020 оны жилийн эцсийн байдлаар нийт 123 өдрийн арилжаа явагдаж, 746,000 ширхэг хувьцааг 25,367,600 төгрөгөөр арилжигдсан байна. 2020 онд “Анд-Энерги” ХК-ийн AND хувьцааны дээд ханш 45 төгрөг, доод ханш 26 төгрөг, дундаж үнэ 34 төгрөг, 12 дугаар 31-ний өдрийн байдлаар хаалтын ханш 40 төгрөг байв.

Арилжаанд “Бумбат-Алтай ҮЦК” ХХК, “Дэлгэрхангай секюритиз ҮЦК” ХХК, “Булган Брокер ҮЦК” ХХК, “Голомт Капитал ҮЦК” ХХК гэсэн үнэт цаасны компаниуд оролцоноос хамгийн өндөр үнийн дүн бүхий арилжааг “Бумбат-Алтай ҮЦК” ХХК хийжээ.

Арилжааны мэдээ, мэдээллийн хувьд СЗХ-ны 2019 оны 1 сарын 09-ний 4 дугаар тогтоолоор баталсан "Хөрөнгийн зах зээлийн зохицуулалттай этгээдээс мэдээлэл ирүүлэх, түүнд хяналт тавих журам"-ын 2 дугаар бүлгийн 2.1 дэх заалтын дагуу 2020 оны 1 дүгээр сараас 12 дугаар сарын арилжааны мэдээлэл болон долоо хоног бүрийн арилжааны мэдээллийг холбогдох маягтаар бэлтгэн СЗХ-нд хүргүүлсэн. Сар бүр арилжааны статистик мэдээлэл, үнэт цаасны өсөлт бууралт, зах зээлийн үнэлгээний мэдээллээс гадна сар бүр арилжааны шимтгэл, үнэт цаас гаргагчтай холбоотой ногдол ашиг, үнэт цаасны компаниудын зохицуулалттай этгээдийн үйлчилгээний хөлсний мэдээний хамт тогтмол хүргүүлж байна.

Арилжааны бодит цагийн болон арилжааны дараах өдөр тутмын мэдээллийг бид www.msx.mn цахим хаягаар дамжуулан олон нийтэд тогтмол хүргэж байна.

Төлбөр тооцоо

Бирж нь 2020 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр “Бумбат-Алтай ҮЦК ” ХХК–тай “Төв клирингийн гишүүнчлэлийн гэрээ”- г байгуулан тооцооны шууд гишүүнээр элсүүлж, 2020 оны эцсийн байдлаар нийт 3 тооцооны гишүүнтэй боллоо.

Биржээс өгсөн зөвшөөрлийн дагуу тооцооны гишүүд 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 50,735,200 төгрөгийн төлбөр тооцоо гүйцэтгэсэн байна. Үүнээс “Нэрэн клиринг” ХХК 4,935,100 төгрөгийн, “Харз трейд ББСБ” ХХК 5,432,300 төгрөгийн, “Бумбат-Алтай ҮЦК ” ХХК 40,367,800 төгрөгийн төлбөр тооцоо гүйцэтгэжээ. 2020 оны эцсийн байдлаар нийт 290 хэлцэл хийгдсэн байна.

Биржийн бус зах зээлийн хувьд “Инвекор ББСБ” ХК болон “Хатан суудал инвест ББСБ” ХХК-ийн өргөдөл, тооцооны үйл ажиллагаа гүйцэтгэх хүсэлтийг хүлээн авч “Төлбөр тооцоо гүйцэтгэх гэрээ” байгуулж, биржийн бус зах зээлд арилжигдсан бондын тооцооны үйл ажиллагааг гүйцэтгэхээр бүртгэсэн. 2020 оны жилийн эцсийн байдлаар “Инвекор” хаалттай бондын 8,200,000,000 төгрөгийн, “Zeely” бондын 277,000,000 төгрөгийн, “МАБУ” бондын 108,000,000 төгрөгийн төлбөр тооцоог тус тус хийж гүйцэтгэсэн байна.

Гишүүнчлэл

Тайлант хугацаанд “Нэйшнл Сэкюритис ҮЦК” ХХК, “Ард Секюритиз ҮЦК” ХХК, “Апекс Капитал ҮЦК” ХХК-ийг арилжааны гишүүнээр бүртгэж, гишүүнчлэлийн гэрээ байгуулсан бөгөөд “Бумбат-Алтай ҮЦК” ХХК-ийг тооцооны гишүүнээр бүртгэж, гэрээ байгуулсан.

2020 оны жилийн эцсийн байдлаар Бирж нийт 17 гишүүн үнэт цаасны компанитай, 3 төлбөр тооцооны гишүүнтэй үйл ажиллагаа явуулж байна.

Санхүү

“Монголын үнэт цаасны бирж” ХК 2020 онд 25,367,600 төгрөгийн арилжаа хийж, арилжаа болон тооцооны шимтгэлд 465.4 мянган төгрөгийн, хаалттай бондын бүртгэлийн хураамж 8.58 сая төгрөгийн, зөвлөх болон гэрээт ажил үйлчилгээний орлогоор 45.0 сая төгрөгийн орлого тус тус олсон байна.

Тайлант хугацаанд компани дүрмийн сангийн хэмжээг 100.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, нийт өөрийн хөрөнгийн хэмжээ 2.83 тэрбум төгрөгт хүрсэн байна. 2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар компанийн балансын нийт хөрөнгийн дүн 2.83 тэрбум төгрөг бөгөөд үүний 5 хувь буюу 137.6 сая төгрөгийг эргэлтийн хөрөнгө бүрдүүлж байна.

Хүснэгт 1. Санхүүгийн тайлангийн хураангуй (сая төгрөгөөр, 2020 оны IV улирал)

№	Санхүүгийн тайлангийн хураангуй үзүүлэлтүүд	Дүн (сая төгрөгөөр)	
		2020.01.01- НЫ үлдэгдэл	2020.12.31- НЫ үлдэгдэл
1	Орлогын дэлгэрэнгүй тайлангийн үзүүлэлтүүд		
1.1	Борлуулалтын орлого	10.42	54.05
1.2	Борлуулалтын өртөг	-	-
1.3	Нийт ашиг	10.42	54.05
1.4	Хүүний орлого	1.16	6.40
1.5	Бусад орлого	21.34	-
1.6	Ерөнхий ба удирдлагын зардал	563.56	503.11
1.7	Санхүүгийн зардал	39.72	62.14
1.8	Бусад зардал	0.23	-
1.9	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.06	0.06
1.10	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(231.75)	-
	Бусад ашиг (алдагдал)	(1,068.98)	
1.11	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(1,871.26)	(511.14)
1.12	Орлогын татварын зардал	0.1	0.00
1.13	Татварын дараах ашиг (алдагдал)	(1,871.36)	(511.14)
2	Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлтүүд		
2.1	Нийт хөрөнгийн дүн	3,021.00	2,831.56
2.2	Үүнээс: Эргэлтийн хөрөнгийн дүн	141.24	137.64
2.3	Өр төлбөрийн дүн	567.08	747.53

Компанийн ТУЗ, хувьцаа эзэмшигчдийн хурал

Тайлант хугацаанд Биржийн ТУЗ нийт 15 удаа хуралдаж, нийт 15 асуудал хэлэлцэн хуралд оролцсон гишүүдийн олонхын саналаар 17 тогтоол гаргаж баталгаажуулсан.

Биржийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг цар тахлын нөхцөл байдлаас хамаарч 2020 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр цахим хэлбэрээр зохион байгуулсан бөгөөд хурлаар компанийн 2019 оны үйл ажиллагаанд ТУЗ-өөс гаргасан дүгнэлтийг баталсан. Мөн түүнчлэн Биржийн 2020 оны болон дунд хугацааны төлөвлөгөөг хувьцаа эзэмшигчдэд танилцуулсан байна.

МОНГОЛЫН ҮНЭТ ЦААСНЫ БИРЖ

УТАС: (+976) 7000-0501, (+976) 7000-0502

ФАКС: (+976) 7011-3722

ЦАХИМ ШУУДАН: INFO@MSX.MN

ХАЯГ: 703 ТООТ ЖИБИ ПЛАЗА, 8-Р ХОРОО, СҮХБААТАР
ДҮҮРЭГ УЛААНБААТАР ХОТ, МОНГОЛ УЛС